

**АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛ,
САР, ДОЛОО ХОНОГИЙН БИЕЛЭЛТИЙН МЭДЭЭ, ТАЙЛАНГ ИРҮҮЛЭХ,
ХҮЛЭЭН АВЧ ДҮГНЭХ ГЭРЭЭ**

2014 оны сарын өдөр

№

Улаанбаатар хот

Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.10, 48 дугаар зүйлийн 48.6.2-48.6.3 дахь хэсэг, Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3-10.1.5 дахь хэсэг, Уул уурхайн сайдын 2013 оны 84 дүгээр тушаалаар батлагдсан “Уул уурхайн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудаас мэдээ, тайлан авах журам”, Ашигт малтмалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2014 оны а-80 дугаар тушаалаар батлагдсан “Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан хүлээж авах заавар”, “Баяжуулах, боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх журам”-д тус тус заасныг үндэслэн:

Нэг талаас Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон баяжуулах, боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч “.....” **ХХК-ийг төлөөлж захирал** **ОВОГТОЙ** /хаяг: Улаанбаатар хот, дүүрэг, –р хороо, –р байр, тоот, улсын бүртгэлийн дугаар, регистрийн дугаар утас:/

- **MV-000000 тоот тусгай зөвшөөрөлтэй**-н алтны орд
- **MV-111111 тоот тусгай зөвшөөрөлтэй**-н төмрийн орд
- **MV-222222 тоот тусгай зөвшөөрөлтэй**-н жоншны орд г.м

Нөгөө талаас Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын холбогдох нэгжийг төлөөлж Уул уурхайн хэлтсийн дарга **Сосорбарам овогтой Баттулга** /хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай-3, Засгийн газрын 12 дугаар байр/ нар дараах нөхцөлийг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээний үндсэн нөхцөл

1.1 Үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж тал нь **2014-2017** онуудын үйл ажиллагааны төлөвлөгөөний жил, сар, долоо хоногийн биелэлтийн мэдээ, тайланг “Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан хүлээж авах заавар”-т заасан хугацааны дотор үнэн зөв гарган Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын холбогдох нэгжид ирүүлнэ.

1.2 Жилийн тайланд Ашигт малтмалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн а-80 тоот тушаалаар батлагдсан “Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан хүлээж авах заавар”-т заасан мэдээ, сарын

тайланд батлагдсан маягтын “Уул уурхайн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудаас мэдээ, тайлан авах журам”-д заасан мэдээ, долоо хоногийн тайланд бүтээгдэхүүн гаргалт, экспортолсон бүтээгдэхүүн, төлөвлөгөө биелээгүй бол түүний шалтгаан, тайлбар бүхий мэдээг тухайн долоо хоног болон жилийн эхнээс өссөн дүнгээр гаргаж тусгана.

Хоёр. Гэрээний хугацаа

2.1 Талууд гэрээг 2014 оны дугаар (дүгээр) сарын-ны өдрөөс эхлэн 2017 оны дугаар (дүгээр) сарын-ны өдөр хүртэл гурван жилийн хугацаатай байгуулав.

Гурав. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон баяжуулах, боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжийн эрх, үүрэг

3.1 Тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг гүйцэтгэх явцад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас төлөвлөгөөг гүйцэтгэх боломжгүй болсон бол сар, долоо хоногийн мэдээг ирүүлэхдээ энэ талаар тайлбар бичиж, шаардлагатай баримт, материалын хамт бичгээр хүргүүлнэ.

3.2 Тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажилд өөрчлөлт оруулах бол энэ тухайгаа долоо хоног, сарын мэдээ гаргахаасаа өмнө урьдчилан мэдэгдэж, шаардлагатай өөрчлөлтийг оруулж зөвшөөрөгдсөн төлөвлөгөөнд нэмэлт тодотгол хийж хүргүүлнэ.

3.3 Энэхүү гэрээний 3.2-д заасан өөрчлөлтийг баталгаажуулсан бол тухайн өөрчлөлт орсон байдлаар сар, долоо хоногийн мэдээ гаргана.

3.4 Сар болон долоо хоногийн мэдээг албан тушаалтай **ОВОГТОЙ** -ын цахим хаягаас хүргүүлэх эсвэл, дугаарын утаснаас мэдэгдэнэ.

3.5 Мэдээ өгөх албан тушаалтан болон түүний цахим хаяг, утасны дугаар өөрчлөгдсөн тохиолдолд ажлын 3 хоногийн дотор төрийн Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын холбогдох нэгжид мэдэгдэнэ.

Дөрөв. Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын холбогдох нэгжийн эрх, үүрэг

4.1 Ирүүлсэн мэдээ, тайланг хүлээн авч, тайланд тусгасан мэдээлэл, холбогдох материалыг шалгаж, дүгнэлт гаргана.

4.2 Ирүүлсэн мэдээ, тайланг буруу, алдаатай гаргасан бол энэ талаар үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжид мэдэгдэж, хариу тайлбар, шаардлагатай баримт, материалыг ирүүлэхийг мэдэгдэнэ.

4.3 Мэдээ, тайланг хүлээн авсны дараа нэгтгэсэн боловсруулалт хийж, дүгнэлт гарган, долоо хоногийн мэдээг баасан гариг бүр, сарын мэдээг сар бүрийн 5-ны өдөрт багтаан, жилийн мэдээг Ашигт малтмалын тухай хуульд заасан хугацаанд Уул уурхайн яам, холбогдох нэгжид хүргүүлнэ.

4.4 Мэдээ, тайланг албан тушаалтай –ын **mining_report@yahoo.com** цахим хаягаар эсвэл **51-263709** дугаарын утсаар хүлээн авна.

Тав. Хүлээх хариуцлага

5.1 Үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж нь энэхүү гэрээнд заасан үүргээ огт биелүүлээгүй, мэдээ, тайланг ирүүлээгүй шалтгаанаа тайлбар, холбогдох материалын хамт удаа дараа ирүүлээгүй бол энэ талаарх зөрчлийг Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын холбогдох нэгж баримтжуулан Ашигт малтмалын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.2 дахь хэсэгт заасан хариуцлага хүлээлгэх саналыг Мэргэжлийн хяналтын байгууллагад эсхүл Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4-10.1.5 дахь хэсэгт заасны дагуу тухайн тусгай зөвшөөрлийг тодорхой хугацаагаар түдгэлзүүлэх, эсхүл тусгай зөвшөөрлийг цуцлах саналыг Кадастрын асуудал хариуцсан нэгжид гаргана.

Гэрээ байгуулсан:

Үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж талыг төлөөлж:

“.....” ХХК-ийн захирал
..... ОВОГТОЙ

_____/гарын үсэг/

Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын холбогдох нэгжийг төлөөлж:

АМГ-ын Уул уурхайн хэлстийн дарга
Сосорбарам овогтой Баттулга

_____/гарын үсэг/